



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорнод аймгийн Баянтүмэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/20/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2020 он

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа

Утас: 7058-4204 Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn

Аудитор: О.Эрдэнэтуяа

Утас: 7000-3775 Цахим хаяг: edi_7855@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НӨАТТХ	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль



Агуулга

Аудитын гэрчилгээ	3
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	10
3.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	11
3.2. Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
3.3. Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
3.4. Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлтийн тайлан	15
3.5. Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	16

Аудитын гэрчилгээ

БАЯНТҮМЭН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Х.ОТГОНЖАРГАЛ
ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянтүмэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянтүмэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянтүмэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх заалтын дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.1. Оршил

Баянтүмэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Отгонжаргал Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянтүмэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянтүмэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 15-наас 2020 оны 02 дугаар сарын 23-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 23-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн гэрээт аудитор О.Эрдэнэтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Баянтүмэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 05 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Баянтүмэн сумын ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Эрүүл чийрэг, зөв төлөвшилтэй, сурлагын чанараа ахиулсан, бүтээлч хүүхдийг төлөвшүүлэх”-д оршино.

Баянтүмэн сумын ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- суралцагчдад боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх
- хүүхдийн хөгжих, төлөвших үйл явцыг шинжлэх ухааны үндэстэй удирдах, зохион байгуулах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Баянтүмэн сумын ерөнхий боловсролын сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна. Баянтүмэн сумын ерөнхий боловсролын сургууль нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд AXPLORER программ хангамж ашигладаг байна.

Баянтүмэн сумын ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баянтүмэн сумын ерөнхий боловсролын сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 34 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 360,980.1 мянган төгрөгөөс тооцон 7,739.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, гүйцэтгэлийн үе шатанд хэвээр баталгаажууллаа.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянтүмэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 203,073.2 мянган төгрөгөөр буюу 167 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	1,220.1	1,220.1	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	27,736.9	36,038.4	8,301.5
Үндсэн хөрөнгө	354,762.3	578,631.2	223,868.9
Элэгдэл	-80,629.5	-109,726.8	-29,097.3
Нийт хөрөнгө	303,089.9	506,163.0	203,073.2
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	303,089.9	506,163.0	203,073.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	303,089.9	506,163.0	203,073.2

Авлага дансны үлдэгдэл нь 2005-2013 онуудад үүссэн, олон жил болсон хувь хүмүүсээс авах авах авлагууд байна. /Эзэн холбогдогчийг нь тодруулахад 2012 онд таван жилийн тэтгэмжийн илүү олгосон 677.6 мянган төгрөгийн өглөгийг төлөөгүй, 542.5 мянган төгрөгийн авлагыг захирал хариуцаж 2017 онд тушаасан гэх боловч баримт нь олдохгүй тул данснаас хасалт хийгээгүй байна./

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь батлагдсан төсвөөс дотуур байрны хүүхдийн цагаан хэрэглэл, гудас, хөнжил, цонхны хөшиг зэргийг 6,505.1 мянган төгрөгөөр худалдан авч, Боловсрол соёл урлагийн газраас 1,796.4 мянган төгрөгийн ном, сурах бичиг үнэ төлбөргүй өгснөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр 49,995.0 мянган төгрөгийн эко автобус, дотуур байрны дээвэр, 73,224.4 мянган төгрөгийн гадна фасадны засвар, 89,574.1 мянган төгрөгийн дотуур байрны ариун цэврийн байгууламж, 2,500.0 мянган төгрөгийн камержуулалт, хамт олны хандиваар 2,900.0 мянган төгрөгийн асар, сүүдрэвчийг тус тус үнэ төлбөргүй хүлээн авч, төсвөөс 5,675.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авсантай холбоотой байна.

Биет бус хөрөнгө 2019 оны жилийн эцсийн тайлангаар өөрчлөлт ороогүй болно.

Өр төлбөр дансны үлдэгдэл үлдэгдэлгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 506,163.0 мянган төгрөг болж 203,073.2 мянган төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгийн орлогоос шалтгаалжээ.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан үндсэн үйл ажиллагаанд 369,245.0 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 321,639.0 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжих тусгай зориулалтын шилжүүлгээр, 25,000.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 3.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 367,863.9 мөнгөн төгрөг буюу 99,6 хувьтай байгаа нь түлш халаалтын зардал хэмнэгдсэнтэй холбоотой.

Нэмэлт төсөв: Нэмэлт санхүүжилтийн дансаар дамжсан орлого, зарлагын гүйлгээ байхгүй байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 34 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 34 эрсдэл тодорхойлж нийт 34 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 37,910.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 2,177.2 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 35,733.4 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1.Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал

Нийт худалдан авалтын 58,6 хувь буюу 29,0 сая төгрөг нь татварын нэгдсэн цахим хуудас дахь ибаримт системд бүртгэгдээгүй байна. Энэ нь *үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3 дахь заалтад “анхан шатны баримт гэж, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 13.4 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Төсвийн тухай хуулийн 41.2.3 дахь заалтад “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

2.Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал

Тээвэр шатахууны зардлаас бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс 400.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь *Төсвийн тухай хуулийн 22.1 “Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана.” 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”* гэсэн заалтуудад нийцэхгүй санхүүгийн тайлангийн хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

3.Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал

Түлш, шатах тослох материалын эхний, эцсийн үлдэгдэлд 300.0 мянган төгрөгийн шатахууныг тайлагнасан байна. Энэ нь *Төсвийн тухай хуулийн 41.2.3 “Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”* гэсэн заалтад нийцэхгүй санхүүгийн тайлангийн хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

4. Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаа

Захирлын тушаалаар ажилчдад сахилгын шийтгэл ногдуулсан байна. Шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй байхад 1,877.2 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон нь *Төсвийн тухай хуулийн 41.2.3 “Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”* заалтад нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

5. Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаа

Бараа материал дансны эхний, эцсийн үлдэгдэлд 6,291.2 мянган төгрөгийг материалыг бөөн дүнгээр тайлагнасан байна. Хөрөнгийн нэр, төрөл, үнийн дүнг тусгаагүй зөрчил нь *Төсвийн тухай хуулийн 41.2.3 “Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”* заалтад нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Авлагын үлдэгдлийг барагдуулсан эсэх асуудал аудитын явцад бүрэн шийдвэрлэгдээгүй тул сумын нэгтгэсэн тайланд дахин хянах шаардлагатай. /Материаллаг дүнгээс бага тул тайлангийн дүгнэлтэд нөлөөлөөгүй болно./

2.12. Шилэн дансны мэдээлэл

Баянтүмэн сумын ерөнхий боловсролын сургууль нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 140 мэдээллийг хугацаанд нь, 10 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянтүмэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорнод аймгийн Баянтүмэн сумын ерөнхий боловсролын сургууль 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3.1 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>28,957,118.83</u>	<u>37,258,633.33</u>
33	АВЛАГА	1,220,150.00	1,220,150.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,220,150.00	1,220,150.00
35	БАРАА МАТЕРИАЛ	27,736,968.83	36,038,483.33
354	Хангамжийн материал	27,736,968.83	36,038,483.33
35410	Бичиг хэргийн материал	154,000.00	184,000.00
35420	Аж ахуйн материал	24,089,828.25	24,089,828.25
35430	Сэлбэг хэрэгсэл	51,200.00	51,200.00
35440	Түлш, шатах тослох материал	300,002.38	300,002.38
35450	Барилгын засварын материал	2,457,000.00	2,457,000.00
35470	Бусад хангамжийн материал	684,938.20	8,956,452.70
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>274,132,774.77</u>	<u>468,904,438.91</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	274,132,774.77	468,904,438.91
392	Биет хөрөнгө	248,074,774.77	442,846,438.91
39201	Барилга, байгууламж, орон сууц	176,790,803.30	339,589,444.30
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(15,054,148.92)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	-	49,995,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	79,174,261.92	84,794,061.92
39206	Хуримтлагдсан элэгдэл	(58,140,397.73)	(67,304,664.16)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	47,509,989.46	49,766,189.46
39208	Хуримтлагдсан элэгдэл	(22,061,152.88)	(26,692,711.03)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	14,600,000.00	14,600,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	140,000.00	3,040,000.00



39215	Хуримтлагдсан элэгдэл	(28,000.08)	(275,333.44)
39217	Ном	10,089,270.78	10,388,600.78
393	Биет бус хөрөнгө	26,058,000.00	26,058,000.00
39301	Програм хангамж	400,000.00	400,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(400,000.00)	(400,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	26,058,000.00	26,058,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>303,089,893.59</u>	<u>506,163,072.23</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>0.00</u>	<u>0.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
413	Өглөг	0.00	0.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>303,089,893.60</u>	<u>506,163,072.24</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	303,089,893.60	506,163,072.24
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	133,071,561.88	133,071,561.88
51101	Өмч: - төрийн	133,071,561.88	133,071,561.88
512	Хуримтлагдсан үр дүн	(223,985,371.75)	(20,912,193.11)
51210	Өмнөх үеийн үр дүн	(223,985,371.75)	(223,985,371.75)
51220	Тайлант үеийн үр дүн	-	203,073,178.64
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	394,003,703.47	394,003,703.47
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>303,089,893.60</u>	<u>506,163,072.24</u>

СТ-2А

3.2 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	321,885,600.00	590,053,285.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20,462,500.00	220,808,285.50
120	Нийтлэг татварын бус орлого	20,462,500.00	220,808,285.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	20,462,500.00	220,808,285.50



Баянтүмэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	20,462,500.00	220,808,285.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	301,423,100.00	369,245,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	299,988,100.00	344,245,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	299,988,100.00	344,245,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,435,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,435,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	25,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	25,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	366,259,999.61	386,980,106.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	366,259,999.61	386,980,106.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	350,122,910.61	378,829,073.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	212,124,652.00	264,124,086.00
210101	Үндсэн цалин	157,984,741.00	189,596,540.00
210102	Нэмэгдэл	23,731,000.00	50,837,804.00
210104	Урамшуулал	15,717,311.00	23,689,742.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,458,600.00	33,217,536.00
210201	Тэтгэврийн даатгал	16,971,800.00	22,597,432.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,121,700.00	2,520,014.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,697,400.00	2,259,038.00
210204	Ажилгүйдлийн даатгал	424,400.00	531,005.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,243,300.00	5,310,047.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,119,866.00	21,825,475.00
210301	Гэрэл, цахилгаан	3,566,266.00	5,456,235.00
210302	Түлш, халаалт	16,054,200.00	14,809,240.00
210303	Цэвэр, бохир ус	1,499,400.00	1,560,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,256,597.62	8,109,400.00
210401	Бичиг хэрэг	460,800.00	1,810,600.00



210402	Тээвэр, шатахуун	2,724,697.62	4,400,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	280,000.00	198,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,791,100.00	1,700,000.00
2105	Нормативт зардал	13,419,318.21	17,639,970.00
210502	Хоол, хүнс	13,357,818.21	15,829,970.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,810,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,896,200.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	1,896,200.00	2,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,998,600.00	2,080,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,818,600.00	1,900,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	180,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	67,849,076.78	29,832,606.86
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,105,200.00	735,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	65,523,876.78	29,097,306.86
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,137,089.00	8,151,033.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,112,232.00	6,770,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,335,832.00	6,770,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	1,174,525.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,174,525.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	24,857.00	206,508.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,857.00	206,508.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(44,374,399.61)</u>	<u>203,073,178.64</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(198,624,400.31)</u>	<u>203,073,178.64</u>

СТ-3А

3.3 АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/



Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	301,423,100.00	369,245,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	301,423,100.00	369,245,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	299,988,100.00	344,245,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	299,988,100.00	344,245,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,435,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,435,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	25,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	25,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	301,423,100.00	369,245,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	301,423,100.00	369,245,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	285,662,183.00	361,093,967.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	212,124,652.00	264,124,086.00
210101	Үндсэн цалин	157,984,741.00	189,596,540.00
210102	Нэмэгдэл	23,731,000.00	50,837,804.00
210104	Урамшуулал	15,717,311.00	23,689,742.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,458,600.00	33,217,536.00
210201	Тэтгэврийн даатгал	16,971,800.00	22,597,432.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,121,700.00	2,520,014.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,697,400.00	2,259,038.00
210204	Ажилгүйдлийн даатгал	424,400.00	531,005.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,243,300.00	5,310,047.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,119,866.00	21,825,475.00
210301	Гэрэл, цахилгаан	3,566,266.00	5,456,235.00
210302	Түлш, халаалт	16,054,200.00	14,809,240.00
210303	Цэвэр, бохир ус	1,499,400.00	1,560,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,001,600.00	8,164,400.00
210401	Бичиг хэрэг	500,800.00	1,865,600.00
210402	Тээвэр, шатахуун	3,024,700.00	4,400,000.00



210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	280,000.00	198,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,196,100.00	1,700,000.00
2105	Нормативт зардал	13,777,465.00	25,029,970.00
210502	Хоол, хүнс	13,715,965.00	15,829,970.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	9,200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,896,200.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	1,896,200.00	2,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,998,600.00	2,080,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,818,600.00	1,900,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	180,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,285,200.00	4,652,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,065,200.00	4,652,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,760,917.00	8,151,033.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,736,060.00	6,770,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	5,959,660.00	6,770,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	1,174,525.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,174,525.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	24,857.00	206,508.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,857.00	206,508.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

СТ-4А

3.4 АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
----------	---------------------------------	-----------------------	-------------------	---



2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	133,071,561.88	394,003,703.47	-223,985,371.75	303,089,893.60
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	133,071,561.88	394,003,703.47	-223,985,371.75	303,089,893.60
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	133,071,561.88	394,003,703.47	-223,985,371.75	303,089,893.60
2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	133,071,561.88	394,003,703.47	-223,985,371.75	303,089,893.60
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	133,071,561.88	394,003,703.47	-223,985,371.75	303,089,893.60
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	203,073,178.64	203,073,178.64
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	133,071,561.88	394,003,703.47	-20,912,193.11	506,163,072.24

ТГ

3.5 АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	369,245,000.00	367,863,967.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	369,245,000.00	367,863,967.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	362,475,000.00	361,093,967.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	264,125,200.00	264,124,086.00
210101	Үндсэн цалин	191,149,200.00	189,596,540.00



Баянтүмэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210102	Нэмэгдэл	44,209,600.00	50,837,804.00
210104	Урамшуулал	28,766,400.00	23,689,742.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,415,700.00	33,217,536.00
210201	Тэтгэврийн даатгал	22,850,500.00	22,597,432.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,641,200.00	2,520,014.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,112,900.00	2,259,038.00
210204	Ажилгүйдлийн даатгал	528,300.00	531,005.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,282,800.00	5,310,047.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,000,000.00	21,825,475.00
210301	Гэрэл, цахилгаан	5,500,000.00	5,456,235.00
210302	Түлш, халаалт	15,940,000.00	14,809,240.00
210303	Цэвэр, бохир ус	1,560,000.00	1,560,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,165,600.00	8,164,400.00
210401	Бичиг хэрэг	1,865,600.00	1,865,600.00
210402	Тээвэр, шатахуун	4,400,000.00	4,400,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	200,000.00	198,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,700,000.00	1,700,000.00
2105	Нормативт зардал	25,036,000.00	25,029,970.00
210502	Хоол, хүнс	15,836,000.00	15,829,970.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,200,000.00	9,200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	2,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,080,000.00	2,080,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,900,000.00	1,900,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	180,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,652,500.00	4,652,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,652,500.00	4,652,500.00



Баянтүмэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,770,000.00	6,770,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,770,000.00	6,770,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,770,000.00	6,770,000.00

